

# БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ-1

Манай улсын санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 90 гаруй хувийг дангаараа бүрдүүлдэг БАНКНЫ САЛБАР-ын 2022 оны гурав дугаар улирлын онцлох үзүүлэлтүүдийг танилцуулж байна.

## Банкны салбарын ерөнхий тойм

Монгол улс 1991 оноос эхлэн 2 шатлалт банкны тогтолцоонд шилжсэн бөгөөд өнөөдрийн байдлаар нийт арилжааны 12 банк үйл ажиллагаа явуулж байна. Монгол улсын төв банк болох МОНГОЛБАНК нь нийт банкны зохицуулалтыг хийдэг байна.

Өнөөдрийн байдлаар банкны салбарын нийт активын хөрөнгийн хэмжээ 41.4 их наяд төгрөгт хүрсэн байгаа бөгөөд манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 95% –тай тэнцэж байна.

Арилжааны банкнуудаас Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк болон Хас банк нь системийн нөлөө бүхий 5 банк юм. Эдгээр банкнууд өнөөдрийн байдлаар нийт санхүүгийн салбарын 94%-ийг бүрдүүлж байна.

## Салбарын голлох үзүүлэлтүүд

Банкны салбарын нийт актив 2022 оны 3-р улиралд 41.4 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5 хувиар нэмэгдлээ.


Харин иргэдийн зээлийн чанар аажмаар муудаж байна. Нийт зээлийн үлдэгдлийн 10% нь чанаргүй байна.

Банкны салбарын аж ахуйн нэгж, иргэдэд ногдох нийт хадгаламж, харилцах дансны үйлчилгээний үлдэгдэл дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад харилцах данс 37.3%, хадгаламж 12.8%-иар буурсан байна.



Эх сурвалж: Монголбанк

## Цэвэр ашгийн үзүүлэлт



Монгол улсын ТОП-5 банкны 2022 оны гурав дугаар улирлын цэвэр ашгийг үзүүлэв.

Банкны салбарын системийн нөлөө бүхий 5 банкны цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 275.6 тэрбум төгрөг буюу дунджаар 68.1%-иар өсөж 680 тэрбум төгрөгт хүрсэн нь тус салбарын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Үнийн дүнгээр цэвэр ашгийн 351.7 тэрбум төгрөгийг Хаан банк, 86.8 тэрбум төгрөгийг Төрийн банк бүрдүүлсэн нь салбарын тэргүүлэх үзүүлэлт болсон байна.

Эх сурвалж: Банкнуудын санхүүгийн тайлан